ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/043/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитор: Б.Оюунхэрлэн<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.25 № 352

танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.АРИУНСУВД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал 84 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

011022152

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **499,629,305.00** | **146,782,506.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 444,129,305.00 | 87,082,506.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 393,151,305.00 | 74,482,506.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,781,400.00 | 3,283,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 30,940,498.00 | 46,840,006.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,929,000.00 | 2,929,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 356,500,407.00 | 21,430,000.00 |
| 35600 | Мал амьтад | 50,978,000.00 | 12,600,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 55,500,000.00 | 59,700,000.00 |
| 36600 | Бусад нөөц | 55,500,000.00 | 59,700,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **17,357,801,170.10** | **24,086,378,788.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 17,357,801,170.10 | 24,086,378,788.86 |
| **392** | **Биет хөрөнгө** | 17,087,320,484.16 | 22,062,997,677.59 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,973,579,700.31 | 3,453,528,053.31 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (536,791,587.73) | (624,479,564.39) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 61,164,658.39 | 104,164,658.39 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (29,149,323.20) | (57,356,110.26) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 436,511,970.00 | 711,504,820.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (193,604,231.00) | (245,219,479.11) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 173,770,836.13 | 205,166,636.13 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (141,515,217.57) | (139,874,349.74) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 9,351,658,103.30 | 13,742,774,776.30 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (1,626,373,979.40) | (2,360,160,909.74) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,624,542,469.00 | 1,660,303,299.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,201,685,866.00 | 8,582,425,248.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,208,158,780.07) | (2,969,779,400.30) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 270,480,685.94 | 2,023,381,111.27 |
| 39301 | Програм хангамж | 3,952,200.00 | 3,952,200.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,546,999.86) | (3,209,462.05) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 446,343,995.00 | 2,206,263,995.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (177,268,509.20) | (183,625,621.68) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **17,857,430,475.10** | **24,233,161,294.86** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **17,857,430,475.10** | **24,233,161,294.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 17,857,430,475.10 | 24,233,161,294.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,217,545,201.36 | 2,217,545,201.36 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,217,545,201.36 | 2,217,545,201.36 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 15,291,116,630.97 | 21,666,847,450.73 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 15,291,116,630.97 | 15,291,116,630.97 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 6,375,730,819.76 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 348,768,642.77 | 348,768,642.77 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **17,857,430,475.10** | **24,233,161,294.86** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **10,399,562,849.90** | **14,077,344,550.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **7,027,036,020.90** | **8,699,164,937.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 7,027,036,020.90 | 8,699,164,937.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 4,080,000.00 | 7,200,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй авсан ҮХ | 6,734,654,910.40 | 8,627,244,937.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй авсан БМ | 288,301,110.50 | 64,720,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,372,526,829.00** | **5,378,179,613.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 151,126,129.00 | 260,217,713.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 4,126,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 123,769,784.00 | 243,385,874.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,356,345.00 | 12,705,839.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 3,221,400,700.00 | 5,117,961,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 3,221,400,700.00 | 5,117,961,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,322,796,571.61** | **7,422,717,185.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,322,796,571.61** | **7,422,717,185.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,271,509,907.92 | 7,130,164,277.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,337,351,304.06 | 2,091,164,086.49 |
| 210101 | Үндсэн цалин | 718,150,769.51 | 762,917,372.00 |
| 210102 | Нэмэгдэл | 409,792,285.67 | 1,041,836,926.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,902,362.63 | 8,730,000.00 |
| 210104 | Урамшуулал | 180,505,886.25 | 277,679,788.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 152,006,078.11 | 240,662,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 103,707,889.09 | 163,586,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,378,273.55 | 15,415,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,450,615.76 | 19,269,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,406,507.82 | 3,854,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,062,791.89 | 38,538,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 59,595,799.50 | 59,081,634.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,500,000.00 | 23,184,883.00 |
| 210302 | Түлш, халаалт | 31,520,348.50 | 27,931,815.15 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,575,451.00 | 7,964,936.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 51,899,114.64 | 38,601,338.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,488,550.00 | 14,896,330.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,036,735.00 | 9,240,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,434,590.64 | 6,074,460.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 24,939,239.00 | 8,390,148.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 54,214,231.00 | 79,274,493.00 |
| 210604 | Урсгал засвар | 54,214,231.00 | 79,274,493.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 216,000.00 | 3,320,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 216,000.00 | 3,320,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 834,035,209.36 | 1,316,888,792.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 834,035,209.36 | 1,316,888,792.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,782,192,171.25 | 3,301,171,033.36 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 818,136,085.14 | 1,597,023,460.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 964,056,086.11 | 1,704,147,573.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 51,286,663.69 | 292,552,908.36 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 40,213,309.00 | 135,996,316.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,263,309.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 124,375,793.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,950,000.00 | 11,620,523.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 11,073,354.69 | 156,556,592.36 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,073,354.69 | 156,556,592.36 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **6,076,766,278.29** | **6,654,627,364.64** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 278,896,544.88 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 278,896,544.88 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (278,896,544.88) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **6,076,766,278.29** | **6,375,730,819.76** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,376,606,829.00** | **5,385,379,613.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,080,000.00** | **7,200,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,080,000.00 | 7,200,000.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 4,080,000.00 | 7,200,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,372,526,829.00** | **5,378,179,613.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 151,126,129.00 | 260,217,713.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 4,126,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 123,769,784.00 | 243,385,874.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,356,345.00 | 12,705,839.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 3,221,400,700.00 | 5,117,961,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 3,221,400,700.00 | 5,117,961,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,376,606,829.00** | **5,385,379,613.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,376,606,829.00** | **5,385,379,613.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,325,320,165.31** | **5,092,826,704.64** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,337,351,304.06 | 2,091,164,086.49 |
| 210101 | Үндсэн цалин | 718,150,769.51 | 762,917,372.00 |
| 210102 | Нэмэгдэл | 409,792,285.67 | 1,041,836,926.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,902,362.63 | 8,730,000.00 |
| 210104 | Урамшуулал | 180,505,886.25 | 277,679,788.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 152,006,078.11 | 240,662,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 103,707,889.09 | 163,586,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,378,273.55 | 15,415,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,450,615.76 | 19,269,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,406,507.82 | 3,854,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,062,791.89 | 38,538,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 58,860,000.00 | 59,609,105.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,500,000.00 | 22,337,670.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,784,549.00 | 28,451,785.15 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,575,451.00 | 8,819,650.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,093,885.00 | 38,731,628.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,523,850.00 | 15,922,828.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,357,935.00 | 9,240,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,232,100.00 | 6,074,460.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,980,000.00 | 7,493,940.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 76,711,013.00 | 102,877,322.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 31,473,500.00 | 29,985,000.00 |
| 210602 | Тавилга | - | 19,797,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 45,237,513.00 | 52,094,522.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 216,000.00 | 3,320,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 216,000.00 | 3,320,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 837,800,000.00 | 1,323,196,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 837,800,000.00 | 1,323,196,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 828,281,885.14 | 1,233,265,563.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 828,281,885.14 | 1,233,265,563.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,286,663.69** | **292,552,908.36** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 40,213,309.00 | 135,996,316.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,263,309.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 124,375,793.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,950,000.00 | 11,620,523.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 11,073,354.69 | 156,556,592.36 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,073,354.69 | 156,556,592.36 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,217,545,201.36 | 348,768,642.77 | 15,291,116,630.97 | 17,857,430,475.10 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 2,217,545,201.36 | 348,768,642.77 | 15,291,116,630.97 | 17,857,430,475.10 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,217,545,201.36 | 348,768,642.77 | 15,291,116,630.97 | 17,857,430,475.10 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,217,545,201.36 | 348,768,642.77 | 15,291,116,630.97 | 17,857,430,475.10 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 2,217,545,201.36 | 348,768,642.77 | 15,291,116,630.97 | 17,857,430,475.10 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 6,375,730,819.76 | 6,375,730,819.76 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,217,545,201.36** | **348,768,642.77** | **21,666,847,450.73** | **24,233,161,294.86** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 5,123,161,930.00 | 4,968,605,307.64 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 5,123,161,930.00 | 4,968,605,307.64 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,987,319,930.00 | 4,833,608,991.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,926,902,500.00 | 1,918,364,086.49 |
| 210101 | Үндсэн цалин | 758,000,000.00 | 762,917,372.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,124,772,500.00 | 1,041,836,926.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,730,000.00 | 8,730,000.00 |
| 210104 | Урамшуулал | 35,400,000.00 | 104,879,788.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 240,862,900.00 | 240,662,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 163,786,900.00 | 163,586,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,415,000.00 | 15,415,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 19,269,000.00 | 19,269,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,854,000.00 | 3,854,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 38,538,000.00 | 38,538,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 59,096,230.00 | 58,271,435.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,000,000.00 | 21,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,097,000.00 | 28,451,785.15 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,999,230.00 | 8,819,650.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,202,400.00 | 38,731,628.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 15,933,600.00 | 15,922,828.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,400,000.00 | 9,240,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,400,000.00 | 6,074,460.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,468,800.00 | 7,493,940.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 91,500,000.00 | 90,793,143.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,000,000.00 | 29,985,000.00 |
| 210602 | Тавилга | 20,000,000.00 | 19,797,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,500,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 40,000,000.00 | 40,010,343.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,000,000.00 | 3,320,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,000,000.00 | 3,320,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,323,196,100.00 | 1,323,196,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,323,196,100.00 | 1,323,196,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,299,559,800.00 | 1,160,269,699.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,299,559,800.00 | 1,160,269,699.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 135,842,000.00 | 134,996,316.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 135,842,000.00 | 134,996,316.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 124,842,000.00 | 124,075,793.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,000,000.00 | 10,920,523.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5,123,161,930.00 | 4,968,605,307.64 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 5,117,961,930.00 | 4,961,405,307.64 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 5,117,961,930.00 | 4,961,405,307.64 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 5,200,000.00 | 7,200,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,200,000.00 | 7,200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **77.00** | **72.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 44.00 | 40.00 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 3.00 | 3.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 13.00 | 12.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 13.00 | 13.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **260,217,713.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **260,217,713.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 259,217,713.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 172,800,000.00 |
| 210104 | Урамшуулал | 172,800,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,337,670.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,337,670.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,084,179.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,084,179.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 72,995,864.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,995,864.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 260,217,713.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 260,217,713.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,126,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 243,385,874.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,705,839.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар 12.2 сая төгрөгийн хөрөнгө бүртгэл тайланд тусгаагүй байсан 1 алдааг илрүүлж, аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 410.0 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс, 394.5 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.7 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12.9 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.1 Албан шаардлага

1. Төрийн албаны цалингийн нэгдсэн системд цалин бодохдоо ирцийн бүртгэлийг буруу оруулснаас үүдэн цалинтай чөлөө авсан албан хаагчдад 1.6 сая төгрөгийн нэмэгдэл цалин хөлсийг олгосон. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн *42.1.3.гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;* гэж заасантай нийцэхгүй байна.

2. Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т "сул орон тоо" гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг; Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг

түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.4-т Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно. .....; гэж заасан байна. Тамгын газрын даргын сул орон тоог түр орлон гүйцэтгүүлэхдээ 40 хувийн нэмэгдэл олгосон.

3. Тус байгууллагад бүртгэлтэй 393.0 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг бусад байгууллага ашиглалтын гэрээгүй ашиглаж байна. Хөрөнгө ашиглалтын гэрээ хийж, хөрөнгийн хяналт, бүртгэлийг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглаж байгаа байгууллагад нь шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай бөгөөд цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.2-т *“төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.”* гэж заасны дагуу сумын төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагад хөрөнгө бэлтгэж өгөх асуудлыг таслан зогсоох.

### 3.2 Төлбөрийн акт

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 5-р хавсралтын *2.2.Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.* гэсэн заалтыг зөрчиж, Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт 2.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал давхардуулж олгосон.

### 3.3 Зөвлөмж

*1. Илрүүлэлт* Ахмадын сангийн данс нь арилжааны банканд байна.

*Өгсөн зөвлөмж* "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам" Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор шинэчлэгдэн 2025 оны 01-р сарын 01-ний өдрөөс даган мөрдөж байгаа бөгөөд уг журмын 1.5.Төсвийн байгууллага ахмадын сангийн хөрөнгийг Төрийн сангийн дансанд байршуулна. гэж заасны дагуу ахмадын сангийн дансыг төрийн сангийн дансанд байршуулах.

2. *Илрүүлэлт:* Орон нутгийн сонгуулийн үр дүнд иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн иргэнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 -д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно." гэж заасны дагуу 12.9 сая төгрөгийн тэтгэмжийг олгоогүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн иргэнд тэтгэмж олгох ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөрөнгийг бүртгэлд тусгаагүй | 1 | 12,210.0 | 1 | 12,210.0 | | | | | | | | |
| | 1 | 12,210.0 | 1 | 12,210.0 | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ахмадын сангийн данс арилжааны банканд бүртгэлтэй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн иргэнд хуулийн дагуу | 1 | 12,870.0 | | | | | 1 | 12,870.0 | | | | |
| Цалинтай чөлөө олгохдоо нэмэгдлүүдийг бодож олгосон | 1 | 1,550.1 | | | 1 | 1,550.1 | | | | | | |
| Түр орлон гүйцэтгүүлэхдээ нэмэгдлийг журмын дагуу олгоогүй | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Хөрөнгө ашиглалтын гэрээгүйгээр бусад байгууллагад хөрөнгө ашиглуулж байна. | 1 | 392,960.0 | | | 1 | 392,960.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үр дүнгийн урамшууллыг давхардуулж, балансын урамшуулал олгосон | 1 | 2,656.8 | 1 | 2,656.8 | | | | | | | | |
| **Дүн** | **6** | **410,036.9** | **1** | **2,656.8** | **3** | **394,510.1** | **2** | **12,870.0** | | | | |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр    Дугаар 01/88 ДОА 2025/043/НА-СТА-ТШВ А1170311    Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 6 албан хаагчид 38 өдрийн цалинтай чөлөө олгохдоо 1,550.1 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйл. Хувийн чөлөө олгох. *100.1.1-д "Ажил олгогч ажилтны хүсэлтээр хувийн чөлөө олгож болно", 100.1.2-т "Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна"*, 42-р зүйлийн 42.1.3-т *"Гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах"* гэж заасантай тус тус нийцэхгүй мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-*д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын *4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Ариунсувд, нягтлан бодогч Д.Алтансувд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР Б.ОЮУНХЭРЛЭН

2125040207

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 02/89 ДОА-2025/0431/НА-СТА-ТШ3 А1170311 Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тамгын газрын даргын сул орон тоог түр орлон гүйцэтгүүлэхдээ 40 хувийн нэмэгдэл олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн *3.1.4."сул орон тоо" гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг;* Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын *2.4.Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно. .....;* гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *“Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”,* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын *4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Ариунсувд, нягтлан бодогч Д.Алтансувд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР Б.ОЮУНХЭРЛЭН

2117144069
ХТУ4337 9935291

2125040202

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 03/91 ДОА-2025/043/НА-СТА-ТШ3 А1170311 Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 393.0 сая төгрөгийн дансны үнэтэй хөрөнгө өөр байгууллагуудад ашиглалтын гэрээгүй ашиглагдаж байна.

Энэ нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдан борлуулах, ашиглуулах, түрээслүүлэх үлгэрчилсэн журам”-ын 4.1-д Эд хөрөнгийг ашиглуулахдаа хуулийн этгээдтэй *“Эд хөрөнгө ашиглалтын гэрээ байгуулна”*. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.2-т *“төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.”* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *“Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын *4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгө ашиглалтын гэрээ хийж, хөрөнгийн хяналт, бүртгэлийг сайжруулах, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Ариунсувд, нягтлан бодогч Д.Алтансувд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР Б.ОЮУНХЭРЛЭН

2117144066
ХТҮ4037 9030891

2125040193

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 36 ДОА-2025/043/НА-СТА-ТИ13 А1170311 Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодогч, нярав нарт 2,656.8 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн *15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;* Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6 дахь *Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан"* гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулж олгосон 2,656,800.0 /хоёр сая зургаан зуун тавин зургаан мянга найман зуу/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Г.Ариунсувд, нягтлан бодогч Д.Алтансувд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА
АУДИТОР Б.ОЮУНХЭРЛЭН

2125050110